

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар

Сарын 12-ны өдрийн 505 дугаар тогтоолын хавсралт

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

I. ТАЙЛАНГИЙН ЭХНИЙ ХЭСЭГ

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:

“БиДиСЕК ҮЦК” Хувьцаат Компани

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Залуучуудын өргөн чөлөө-27/1,

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо

Утас: 11-321763

Факс: 11-321763

Электрон хаяг: www.bdsec.mn

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

Улсын бүртгэлийн дугаар: 9010001030

Регистрын дугаар: 2052482

Үйл ажиллагааны чиглэл: Брокер дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 432 /2015 оны 01-р сарын 30-ны өдрөөр/

3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:

Эрхэм зорилго: Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжих, олон улсын стандартанд нийцсэн санхүүгийн зах зээлд тэргүүлэгч байгууллага болох.

4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухай зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн үйл ажиллагаа Монгол Улсад Хөрөнгийн Зах Зээл үүссэн 1991 оноос эхэлсэн бөгөөд өдгөө 24 дэхь жилдээ үйл ажиллагаагаа явуулж буй тус салбарын ууган компаниудын нэг юм.

БиДиСЕК нь Монголын Хөрөнгийн зах зээл дээр Андеррайтер, Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг гадаад дотоодын харилцагчид,

түнш байгууллагууддаа цогцоор нь чанарын өндөр түвшинд үзүүлж, урт хугацааны итгэлтэй түншлэлийн харилцааг эрхэмлэн ажиллаж ирсэний үр дүнд дотоодын Хөрөнгийн зах зээлийн тэргүүлэгч компани болж чадсан.

Энэ бүхнийг манай компанийн үйлчилж буй харилцагчидын тоо, үнэт цаасны арилжааны хэмжээ, гаргасан IPO, санхүүгийн чадвар, тогтвортой байдал, харилцагчиддаа үзүүлдэг үйлчилгээний төрөл зэрэг олон үзүүлэлтүүд илтгэдэг.

Монголын хөрөнгийн зах зээл дээр нийт 17 компанийн "IPO" хийгдсэн бөгөөд "БиДиСЕК ҮЦК" ХК нь үүний 65 хувьд андеррайтераар ажилласан байдаг. Нэмэлтээр гаргасан үнэт цаасны "FPO"-ийн 80 хувьд, нийт гаргасан компанийн бондын 36 хувьд тус тус андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн.

2014 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлд оролцох данстай харилцагчдын тоо, нийт зах зээлийн харилцагчдын 25 хувь буюу 193,000 гаруй харилцагчтай болсон.

Сүүлийн 5 жилд Монголын Хөрөнгийн Бирж дээр хийгдсэн үнэт цаасны арилжааны 42-91 хувийг дангаараа гүйцэтгэсэн байна.

5. Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гаргасан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл:

"БиДиСЕК ҮЦК" ХК-ийн үндсэн бизнес нь Монголын хөрөнгийн зах зээл дээрээс гадаад дотоодын хөрөнгө оруулагчид үнэт цаас худалдан авахад зуучлал /брокер/, аж ахуй нэгжүүдэд үнэт цаас гарган хөрөнгө оруулалт татах андеррайтерийн үйл ажиллагаа юм.

Мөн биржид компаниуд шинээр бүртгүүлэх, бүртгэлтэй хувьцаат компаниудын засаглалыг сайжруулах, үр ашиг бүхий төсөлд хөрөнгө оруулалт татах, иргэдэд үнэт цаасны арилжаанд оролцоход Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг үзүүлдэг.

Эдгээр үйлчилгээнүүдийн манай компанийн салбартаа олон жил ажилласан туршлагатай, чадварлаг удирдлага, зөвлөх мэргэжилтнүүд Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулах байгууллагуудын дүрэм журамд нийцүүлэн чанарын өндөр түвшинд үзүүлж байна.

- 1. Брокерийн үйл ажиллагаа: "БиДиСЕК ҮЦК" ХК нь харилцагч, хөрөнгө оруулагчдад Монголын Хөрөнгийн зах зээл дээрээс үнэт цаас худалдан авах, худалдах захиалгыг зуучлалын үйл ажиллагаа буюу брокерийн үйлчилгээг дамжуулан түргэн шуурхай гүйцэтгэж байна.*

- a. *Тел И брокер*
 - b. *Арилжааны танхим*
 - c. *Сургалт зөвлөгөө*
 - d. *Мэдээлэл, судалгаа*
 - e. *Хөрөнгө оруулагчдын уулзалт*
 - f. *Багцын арилжаа*
 - g. *Бусад нэмэлт үйлчилгээнүүд*
2. *Андеррайтерийн үйлчилгээ: Бид андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжилт шаардлагатай байгаа компанийн үнэт цаасыг хаалттай болон нээлттэй хүрээнд хөрөнгө оруулагчид зуучлан борлуулах, зарим тохиолдолд үнэт цаасыг нь анхдагч зах зээл дээрээс бүхлээр нь болон хэсэгчлэн худалдан авах, үнэт цаасны бүртгэлийн болон анхдагч зах зээлийн арилжааг удирдан зохион байгуулан ажилладаг.*
- a. *Хувьцаагаар санхүүжилт татах*
 - i. *Шууд хөрөнгө оруулалт*
 - ii. *Шинээр хувьцаа гаргах буюу IPO*
 - iii. *Давуу эрхийн хувьцаа*
 - iv. *Нэмэлт хувьцаа гаргах буюу FPO*
 - b. *Зээлийн санхүүжилт*
 - i. *Хаалттай бонд*
 - ii. *Нээлттэй бонд*
 - iii. *Хөрвөх зээл*
 - iv. *Хөрвөх бонд*
3. *Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ: Манай компани 2007 онд “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ноос Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх эрхийг авсанаар үнэт цаасанд хөрөнгө оруулах сонирхолтой хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагад хөрөнгө оруулалт хийхэд нь зөвлөх, санхүүжилт шаардлагатай байгаа компаниудад хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт татах боломжийн талаар зөвлөгөө өгөн ажиллаж байна.*
- a. *Иргэдэд зориулсан цогц үйлчилгээ*
 - b. *Аж ахуйн нэгжүүдэд зориулсан үйлчилгээ*
 - i. *Тендер санал зарлах*
 - ii. *Компанийн хэлбэрийг өөрчлөх*
 - iii. *Хувьцаа эзэмшигчдийн хурал*
 - iv. *Санхүүжилт татах*
 - v. *Компанийн засаглалын зөвлөгөө зэрэг үйлчилгээнүүдийг харилцагч байгууллагуудад хүргэж байна.*

6. Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл:

Компанийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	20.06%
2	Б.Лхагвадорж	Тэргүүн дэд захирал	3.52%
3	Н.Батгэрэл	Дэд захирал	2.40%
4	Firebird MF Holdings S.A.R.L	-	5.40%
5	Firebird Global Master Fund Holdings-1 S.A.R.L	-	5.32%
6	Firebird GM 2 S.A.R.L	-	7.82%
7	Impera Mongolia Holdings Ltd	-	5.41%
8	Alexander Zwahr	-	23.21%

7. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	Дээд	
2	Б.Лхагвадорж	Тэргүүн дэд захирал	Дээд	
3	Н.Батгэрэл	Дэд захирал	Дээд	
4	Nick Cousyn	Үйл ажиллагаа хариуцсан захирал	Дээд	
5	James Passin	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
6	Д.Амгаланбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
7	Hitoshi Tani	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
8	Б.Энхбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
9	Б.Амарсанаа	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
10	Alexus de Mesquenem	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
11	С.Пүрэвсүрэн	Дотоод албаны менежер	Дээд	
12	Ц.Цог	Харилцагчийн албаны менежер	Дээд	
13	Г.Мөнхтулга	Институциональ харилцагчийн албаны менежер	Дээд	
14	Ш.Шинэбаяр	Хөрөнгө оруулалтын албаны менежер	Дээд	
15	О.Уранбайгаль	Back Office менежер	Дээд	
16	Т.Отгонжаргал	Санхүүгийн албаны менежер	Дээд	

8. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	20.06%
2	АНУ-н хөрөнгө оруулалтын сан	-	18.54%
5	Impera Mongolia Holdings Ltd	-	5.41%
6	ХБНГУ-н хөрөнгө оруулагч	-	23.21%

II. ТАЙЛАНГИЙН ХОЁРДАХЬ ХЭСЭГ

1. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

Компанийн 2012, 2013, 2014 оны орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он
Борлуулалт	5,923,680	2,446,064	2,158,871
Борлуулалтын хөнгөлөлт	-	-	-
Цэвэр борлуулалт	5,923,680	2,446,064	2,158,871
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,093,588	650,221	1,259,413
Нийт ашиг	4,830,111	1,795,843	899,458
Үйл ажиллагааны зардал	3,108,205	1,628,571	1,717,312
Үйл ажиллагааны ашиг /алдагдал/	1,721,906	350,395	676,898
Үйл ажиллагааны бус зардал	(56,372)	(27,890)	(36,228)
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	1,665,534	322,969	535,201
Орлогын татварын зардал	174,139	35,086	50,479
Цэвэр ашиг /алдагдал/	1,491,394	287,883	(484,722)

Компанийн 2012, 2013, 2014 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд	2012 он	2013 он	2014 он
Эргэлтийн хөрөнгө	5,986,559	6,244,515	11,200,287
Эргэлтийн бус хөрөнгө	3,763,661	3,505,293	3,527,369
Нийт хөрөнгийн дүн	9,750,220	9,749,808	14,727,657
Богино хугацаат өр төлбөр	219,217	787,156	1,538,653
Урт хугацаат өр төлбөр	61,945	44,542	-

Эзэмшигчдийн өмчийн дүн	9,469,057	8,918,111	13,189,004
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	9,750,220	9,749,808	14,727,657

2. Компани нь 2014 оны жилийн эцсийн байдлаар 2,677.38 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай байгаа ба өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс их байна.

3. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээр нь үнэт цаас эзэмшдэг талаарх мэдээлэл:

№	Овог нэр	Цалин урамшуулалын хэмжээ	Хандив тусламжийн хэмжээ	Бусад	Эзэмшиж буй хувьцааны тоо
1	Б.Лхагвадорж	2,400,000	-	-	3.52%
2	Д.Даянбилгүүн	2,400,000	-	-	20.06%
3	Н.Батгэрэл	2,400,000	-	-	2.44%
4	James Passin	2,400,000	-	-	-
5	Д.Амгаланбаяр	2,400,000	-	-	2.46%
6	Hitoshi Tani	2,400,000	-	-	2.29%
7	Б.Энхбаяр	2,400,000	-	-	0.001%
8	Б.Амарсанаа	2,400,000	-	-	-
9	Alexus de Mecquenem	2,400,000	-	-	-

4. Ногдол ашгийн талаарх мэдээлэл:

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2006 оноос хойш нийтдээ 6 удаа хувьцаа эзэмшигч нартаа ногдол ашиг тараасан ба 2013 онд нэгж хувьцаанд 11.78 төгрөг, 2012 онд нэгж хувьцаанд 60 төгрөг, 2010 онд нэгж хувьцаанд 50 төгрөг, 2008 онд нэгж хувьцаанд 5 төгрөг, 2007 онд нэгж хувьцаанд 30 төгрөг, 2006 онд нэгж хувьцаанд 3 төгрөгийг тус тус тараасан болно.

5. Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаарх мэдээлэл:

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2014 онд “Компанийн тухай хууль”-ийн 87 зүйлд заасан их хэмжээний хэлцэл хийсэн болно.

Компанийн шинээр нэмж гаргасан 6,000,000 ширхэг хувьцаа нь Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.2-т заасан их хэмжээний хэлцэлд хамаарч байгаа болно. Уг асуудлыг 2014 оны 04-р сарын 18-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа эзэмшигчдэд танилцуулан батлуулсан

бөгөөд ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолд дурьдсанаар нэмж гаргах асуудлыг 100 хувийн саналаар зөвшөөрч баталсан болно.

“Компанийн тухай хууль”-ийн 89 дүгээр зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй болно.

6. Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан:

№	Овог нэр	Эрхэлдэг ажил	Эзэмшсэн мэргэжил боловсрол	Эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь	Хараат бус гишүүн эсэх
1	Б.Лхагвадорж	ТУЗ-ийн дарга	Дээд, нефьтийн инженер	3.52%	Хараат
2	Д.Даянбилгүүн	ТУЗ-ийн гишүүн	Дээд, Бизнесийн удирдлага	20.06%	Хараат
3	Н.Батгэрэл	ТУЗ-ийн гишүүн	Дээд, Гадаад харилцааны мэргэжилтэн	2.44%	Хараат
4	James Passin	ТУЗ-ийн гишүүн	Дээд		Хараат
5	Д.Амгаланбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	2.46%	Хараат бус
6	Hitoshi Tani	ТУЗ-ийн гишүүн	Дээд	2.29%	Хараат бус
7	Б.Энхбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	0.001%	Хараат бус
8	Б.Амарсанаа	ТУЗ-ийн гишүүн	Дээд	-	Хараат бус
9	Alexus de Mecquenem	ТУЗ-ийн гишүүн	Дээд	-	Хараат бус

Компани нь 2014 оны 04-р сарын 18-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг зарлан хуралдуулж, ТУЗ-ын гишүүдийг дахин сонгосон бөгөөд 2014 оны 05-р сарын 15-ний өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх дэд хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон:

- a. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын хороог Хитоши Тани, Жэймс Пассин, Д.Амгаланбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Хитоши Тани-г томилсон.
- b. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулалын хороог Н.Батгэрэл, Б.Амарсанаа, Д.Амгаланбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Н.Батгэрэл-г томилсон.
- c. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог Д.Даянбилгүүн, Б.Энхбаяр, Алексис Мекюүнэм гэсэн бүрэлдэхүүнтэйгээр

байгуулан, Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Даянбилгүүн-г томилсон.


2014 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гарган баталж, 4 удаа ирц бүрдүүлэн хуралдаж ХЭХ-аас гаргасан тогтоол шийдвэрийн дагуу 10 асуудал хэлэлцэж нийт хэлэлцсэн асуудлаар 10 тогтоол, 4 тэмдэглэл гарган баталж, гүйцэтгэлд хяналт тавьж дүгнэж ажилласан.

Тайлангийн хугацаанд “Нэр дэвшүүлэх хороо” 2 удаа хуралдаж 2 асуудал, “Аудитын хороо” 2 удаа хуралдаж 2 асуудал, “Цалин урамшуулалын хороо” 2 удаа хуралдаж 2 асуудал тус тус хэлэлцсэн байна. ТУЗ-ийн хурлын дундаж ирц 88.88% байсан. ТУЗ-с гаргасан тогтоол, шийдвэр түүний биелэлтийг өөрийн компанийн цахим хуудсаар цахим хэлбэрээр явуулж тайлагнаж ажилласан.

7. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан:



1. Брокер, дилерийн үйл ажиллагаа

2014 оны Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК дээр нийт 51.30 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэний 42 % буюу 21.79 тэрбум төгрөгийн арилжааг компани хийж гүйцэтгэсэн байна.



1.1. Шинэ данс

2014 онд нийт “ҮЦТТТХТ” ХХК дээр нийт 12,530 ширхэг үнэт цаасны данс нээгдсэний 1,310 нь манай компани дээр данс нээлгэсэн байна.



2. Андеррайтерийн үйл ажиллагаа

2.1. Андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд

Бид андеррайтерийн үйл ажиллагааныхаа хүрээнд Монголын томоохон компани, группүүдэд дотоодын зах зээл дээрээс санхүүжилт босгох, түүнтэй уялдан гарах санхүүгийн болон үнэт цаасны эрх зүйн асуудлыг шийдвэрлэх тал дээр мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг билээ.

Үйл ажиллагаа:



Төсөл:

“БиДиСек” ХК-ийн Хөрөнгө оруулалтын алба 2014 оны байдлаар нийт 27 төсөл хүлээн авсан байна.

“БиДиСек” ХК-ийн FPO



2014 онд “БиДиСек” ХК-ийн нэмэлт үнэт цаасыг гарган нийт 4.89 тэрбум төгрөгийг Хөрөнгийн зах зээл дээрээс татан төвлөрүүллээ. Үүнээс хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжээр 3.77 тэрбум төгрөг, анхдагч зах зээлийн арилжаагаар 1.11 тэрбум төгрөгийг тус тус босгосон байна. Уг хөрөнгөөр компанийн хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн байгаа.

“Хай Би Ойл” ХК-ийн Өрийг хувьцаанд хөрвүүлэх төсөл



“ХайБиОйл” ХХКомпани нь 2000 онд нефтийн бүтээгдэхүүний гадаад, дотоод худалдаа, төсөл боловсруулах чиглэлээр үүсгэн байгуулагдаж байсан.Тус компанид нийт ... тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг 2013 онд татан төвлөрүүлсэн бөгөөд үүнийг хувьцаагаар солих төслийн ажиллагааг гүйцэтгэж байна.

“Эрдэнэс Таван толгой” ХК-д Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэв.



Үндэсний томоохон уул уурхайн компани болох “Эрдэнэс Тавантолгой” ХК-д хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлэв.

2.2. Компаниудтай хамтран ажиллах, харилцааг идэвхжүүлэх ажлын хүрээнд

Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах сонирхол бүхий ХХК болон ХК-иудад зориулсан гарын авлага гаргаж компаниудад хүргүүлэн ажиллаж байна.

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-д бүртгэлтэй ХК-иудад зориулсан гарын авлага болон бусад холбогдох судлагааг тус тус гарган ажиллаж байна. 2013 онд хэрэгжүүлж эхэлсэн ТОП 150 компаниуд болон өсөн дэвжиж буй компаниудыг сонгон “Project hunting” буюу хөрөнгийн зах зээлд гарах боломжийн талаар танилцуулга хийх, холбогдох уулзалтуудыг зохион байгуулах ажлыг 2 дахь жилдээ үргэлжлүүлэн хийж байна.

3. Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ

3.1. Байгууллагын зөвлөх үйлчилгээ

2014 онд байгууллагын зөвлөхийн үйл ажиллагааны хүрээнд дараах төрлүүдээр үйл ажиллагаагаа амжилттай явуулж нийт 17 компанитай гэрээ байгуулан ажиллав.

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал зохион байгуулах
- Хувьцаат компанийн зөвлөх үйлчилгээ /компанийн засаглал, ТУЗ, санхүүжилт татах/

- Тендер санал зарлах
- Компанийн хэлбэрийг өөрчлөх
- Үнэт цаасны арилжааг сэргээх
- Сургалт

2014 онд нийтдээ 10 ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зохион байгуулах, зөвлөх үйлчилгээг үзүүлсэн. 2 ХК-ийн хувьцаагаа эргүүлэн худалдан авах тендер саналын ажлыг зохион байгуулсан. 1 ХК-ийн хэлбэрийг өөрчлөх ХХК болгох ажлыг амжилттай зохион байгуулсан. 2 ХК-тай компанийн засаглалыг сайжруулах гэрээ байгуулан ажилласан.

Мөн 2014 онд “Силикат” ХК-ийн олон нийтэд нэмж гаргасан хувьцаагаа эргүүлэн худалдан авах буюу хувьцаа халааслах үйл ажиллагааг хамтран гүйцэтгэсэн.

4. Судалгаа шинжилгээ

Хөрөнгө оруулагчдад зориулан нийт бүрэн хэмжээний 6 судалгааны бүтээгдэхүүнийг англи болон монгол хэл дээр гаргасан. Үүнд:

- Lackluster 2013 for MSE
- Mongolia Growth Group
- Longer Duration GOM MNT
- A Quantitative Look
- MSE Stealth Bull Market
- Short term Mongolian Bond

Мөн хөрөнгө оруулагчид болон ХК-иудын уулзалтыг тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд 2014 онд нийтдээ давхардсан тоогоор 37 ХК-иудтай өөрсдийн харилцагчид хөрөнгө оруулагчдын уулзалтыг зохион байгуулсан.

Өдөр тутмын болон долоо хоногийн арилжааны мэдээ мэдээллийг монгол болон англи хэлээр харилцагч нарт явуулж байна. Шинээр гарч буй судалгаанууд манай вэб сайт болон Bloomberg Mongolia-д нийтлэгдэж байна.

5. Нийгмийн хариуцлагын хүрээнд

- 6 дахь жилдээ иргэдэд зориулсан Хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох сургалтыг өөрийн байранд зохион байгуулж 2014 онд 800 гаруй иргэдийг хамруулаад байна.
- 2014 оноос эхлэн Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-иас зохион байгуулдаг анхан шатны сургалтад хамтран ажиллаж эхэлсэн ба нийтдээ 400 гаруй иргэд хамрагдаад байна.

- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим /МҮХАҮТ/-тай хамтран гишүүн байгууллагуудын ажилтан албан хаагч нарт зориулан 16 цагийн сургалт лекцийг хамтран зохион байгуулсан.
- Салбарын оролцогч мэргэжлийн байгууллагуудын дунд найрсаг харилцаа үүсгэх, хөдөлгөөн эрүүл мэнд, бие бялдарыг хөгжүүлэх зорилготой уламжлал болгон зохион байгуулдаг “BDS CUP-2014” хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг 7 дахь удаагаа амжилттай зохион байгуулсан. Мөн МХБ-ийн Олон төрөлт тэмцээнийг өндөр түвшинд зохион байгуулж амжилттай оролцсон.
- Мэргэжилтнүүдийн амралт чөлөөт цагийг зөв өнгөрөөх Монгол орны байгалийн үзэсгэлэнт газартай танилцах зорилгоор Сэлэнгэ аймгийн сайхны хөтөл, ээж мод зэргээр аялал зохион байгуулсан.
- МУ-ын ерөнхийлөгчийн санаачлан гаргасан мод тарих үндэсний өдрөөр компанийн нийт мэргэжилтэнүүд идэвхитэй оролцож цэцэрлэгт хүрээлэнд 10 гаруй мод тарьсан.

6. Санхүүгийн тайлан

Манай компани нь санхүүгийн тайлангуудаа Монгол улсад мөрдөгдөж буй хууль, тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн/НББ/ заавар журам болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-н дагуу бэлтгэдэг.

Улсын хэмжээнд даган мөрддөг НББ-ийн дансны нэгдсэн зааврын дагуу үндсэн дансуудыг ангилан, туслах дансуудыг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан коджуулан хэрэглэж байгаа бөгөөд дансны жагсаалт нь баланс болон орлого, үр дүнгийн тайлангуудын дансуудаас бүрддэг.

Санхүүгийн жилийн татвар ногдох орлого, зардлаа Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд бэлтгэн тайлагнадаг.

Санхүүгийн тайлангаа НББ-ийн аккруэл суурьд үндэслэн бэлтгэдэг ба холбогдох хуулийн дагуу улирлын тайлангаа дараа сарын 20-ны дотор, жилийн тайлангаа дараа оны 2 сарын 10-ны дотор баталгаажуулан Чингэлтэй дүүргийн Төрийн сан болон Татварын хэлтэс, МХБ, СЗХ зэрэг байгууллагуудад хүргүүлдэг.


Мөн бид санхүүгийн тайлангаа өөрийн веб сайтандаа байршуулдаг ба энэ нь манай дотоодын харилцагч нараас гадна дэлхийн аль ч улс орноос харилцагчид санхүүгийн мэдээллийг бодитой, шуурхай авах боломжийг олгодог.

Байгууллагын санхүүгийн тайлан хэрэглэгчдийг мэдээллээр хангаж дотоод, гадаад харилцагчдын бэлэн болон бэлэн бус мөнгөний гүйлгээг хурдан шуурхай хийж гүйцэтгэдэг. Санхүүгийн тайланг алдаа зөрчилгүй илэрхийлснээ нотлон хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулан Хараат бус аудиторын дүгнэлт гаргуулдаг бөгөөд 2014 оны тайлант жилд Олон улсын санхүүгийн сүлжээ

байгууллага болох “BDO International” компанийн гишүүн “BDO Audit” ХХК-тай хамтран ажиллаад байна.


6.1. Хөрөнгө

/сая.төгрөгөөр/



Нийт хөрөнгө 2014 онд 14,7 тэрбум буюу 50.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.


Хөрөнгийн бүтэц




Нийт хөрөнгө 14.7 тэрбум төгрөг ба үүнээс 76 хувийг эргэлтийн, 24 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна. Нийт хөрөнгөнд эзлэх эргэлтийн хөрөнгийн

хэмжээ 76% байгаа нь хангалттай сайн үзүүлэлт бөгөөд санхүүгийн хувьд аюулгүй байгааг харуулж байна.

Эргэлтийн хөрөнгө ба богино хугацаат хөрөнгө оруулалт /сая төгрөгөөр/




Эргэлтийн бус хөрөнгө түүний бүтэц /сая төгрөгөөр/




Өр төлбөр ба эздийн өмч

Хөрөнгийн эх үүсвэрийн бүрэлдэхүүн /сая төгрөгөөр/




Эх үүсвэрийн бүтцэд өр төлбөр 40%, эзэмшигчийн өмч 60% байвал санхүүгийн хувьд эрсдэлгүй харьцаа гэж тооцдог бөгөөд манай компаний хувьд 2014 оны байдлаар өр төлбөр 10.8%, эзэмшигчийн өмч 89.2%-ийг эзэлж байгаа нь нилээд өндөр боломжит үзүүлэлт юм.

Орлого, зардал, ашиг




Санхүүгийн шинжилгээ

Шинжилгээ	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Бие даах чадварын коэффициент	95.36%	88.40%	97.00%	91.45%	93.38%
Зохицуулалтын коэффициент	64.07%	54.98%	60.91%	61.19%	71.27%



Зохицуулалтын коэффициент нь өөрийн капиталын эргэлтийн хэсэгт ногдох хувийг харуулдаг. Энэ үзүүлэлт тогтмол өндөр байгаа нь компанийн үйл ажиллагаа тогтвортой, бие даан үйл ажиллагаа явуулах чадвар өндөр байгааг харуулж байна.

Ашигт ажиллагааны шинжилгээ



Зах зээлийн идэвхижилийн шинжилгээ

Шинжилгээ	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	74.50	130.07	135.58	26.17	(42.00)
Зах зээлийн үнэ ба бүртгэлийн үнийн харьцаа (ЗЗҮ/БҮ)	4.27	4.40	4.18	2.96	2.68
Үнэ ашгийн харьцаа (P/E)	33.56	26.91	26.55	91.70	-63.64

EPS буюу нэгж хувьцаанд ногдох ашиг гэдэг нь компанийн нэгж хувьцааны цаана хэдэн төгрөгний ашиг олж байгааг харуулдаг. 2014 онд манай компанийн “Нэгж хувьцаанд ногдох ашиг” (42.00) төгрөг байна.

ЗЗҮ/БҮ нь тухайн үед нэгж хувьцаанд ногдох бодит хөрөнгийн бүртгэлийн үнээс давуулж төлсөн үнэ буюу хөрөнгө оруулагчдын зүгээс компаний ирээдүйд хэр итгэж байгааг харуулдаг чухал үзүүлэлт юм.

P/E буюу үнэ ашгийн харьцаа нь тухайн хувьцааны үнэ зах зээл дээр хэр бодитой үнэлэгдэж байгааг тодорхойлдог үзүүлэлт юм.

7. Онцлох үйл явдалууд

- Дотоодын томоохон нүүрсний салбарын компани болох Эрдэнэс Таван Толгой ХК-ийн зөвлөхийн үйлчилгээний тендер ялалт байгуулан, зөвлөхийн гэрээ байгуулан хамтран ажилласан.
- Монголын хөрөнгийн зах зээл дээр анх удаагаа 1000 хүнийг хамарсан “I Like Mongolian Capital Market” сургалт лекцийг зохион байгуулсан.
- БиДиСЕК ҮЦК ХК-ийн нэмэлт үнэт цаасны тэргүүн ээлжний арилжаа амжилттай явагдсан.
- Нэгдсэн данс буюу номинал дансыг нэвтрүүлсэн.
- Зайнаас буюу онлайн арилжааг нэвтрүүлсэн.
- 2014 оны Онцлох Entrepreneur /МҮХАҮТ/
- Хөрөнгийн Зах зээлийн шилдэг үнэт цаасны компани /МХБ ТӨХК/
- Хөрөнгийн зах зээлд оролцогчдод зориулж зах зээл, үйл явдал, цаг үеийн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэхээр BDsec MARKET WATCH студийг байгуулж нэвтрүүлгээ иргэдэд хүргэж эхэлсэн.

III. ТАЙЛАНГИЙН ГУРАВДАХЬ ХЭСЭГ

Компани нь 2014 оны 04 сарын 18-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн талаар ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан
- b. ТУЗ-ийн ногол ашиг тараах эсэх талаар гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах
- c. Нэмэлт хувьцааны тоог шинэчлэн тогтоох тухай
- d. Компанийн 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
- e. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- f. ТУЗ-ийн 2014 оны цалин урамшуулалын төсөв батлах

Компани нь 2013 оны 04 сарын 24-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- b. 2012 оны компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
- c. Ногдол ашиг хуваарилах тухай
- d. 2013 оны бизнес үйл ажиллагааны төлөвлөгөө
- e. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
- f. ТУЗ-ийн зардлын төсөв батлах тухай
- g. Хаалттай хүрээнд бонд гаргах тухай

Компани нь 2012 оны 04 сарын 30-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- b. Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан болон 2012 оны төлөвлөгөө
- c. Компанийн хянан шалгагчийн тайлан
- d. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төсөл
- e. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
- f. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв зэрэг асуудлыг тус тус хэлэлцэн баталж, хурлаас гаргасан тогтоол шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагуудад хугацаанд тайлагнан ажилласан.